

УГСААТНЫ ЗҮЙН ҮЗЭСГЭЛЭН

Удиртгал

Угсаатны зүйн олон төрлийн үзмэрээр үзэсгэлэн дэглэх ажил дизайнерайн ур чадварыг сорьдог. “Амьдрал тэр чигээрээ л энд байна” гэмээр байдал үүсдэг. Янз бүрийн угсаатан, овог аймгуудыг эд өлгийн соёлоор нь илэрхийлэхэд бүхэл бүтэн байшин сав, модон завьнаас эхлээд хүзүүний зүүлт, өдөөр чимсэн сам зэрэг хувь хүний гоёл чимэглэл хүртэлх маш өргөн цар хүрээний үзмэр, эд өлгийн зүйлийг ашиглах хэрэг гарна. Ийм үзэсгэлэнд сав суулга, иж бүрэн хувцас сэлт, зэр зэвсэг, бурхан тахил болон шүтээн сахиусыг ч оруулна. Бусад цуглуулгатай харьцуулахад угсаатны цуглуулга нь зарим талаараа амьдралын олон талыг хамарсан байдаг.

Угсаатны ихэнх үзмэр овор ихтэй, органик, хэврэг байдаг. Үзэсгэлэнгийн танхимд агааржуулагч байхгүй бол үзмэрийн хадгалалт хамгаалалтын зохистой нөхцлийг хангахад их хүндрэлтэй. Тиймээс үзэсгэлэн зохион байгуулж эхлэхээсээ өмнө үзмэр, эд өлгийн зүйлийн жагсаалтаа сэргээн засварлагч нартай шалгах хэрэгтэй.

Стандарт хэмжээтэй үзмэрийн шилэн хоргонд багтахгааргүй хэт том үзмэрүүдийг хэлбэр хэмжээнд нь тохируулан угсардаг шилэн хоргонд байрлуулж болно. Том том үзмэрүүдийг танхимд ил задгай байрлуулахаар бол суурь тавиур дээр тавиад, хаалт хийж үзэгчдээс зааглана.

Угсаатны үзэсгэлэн дэглэхэд гарах асуудлууд: Үзэгчдэд үзэсгэлэнгийн талаар тойм мэдээлэл өгөх нь

Үзэгчид үзэсгэлэнд тайлбарлан харуулж буй овог аймаг, угсаатны талаар мэддэг байх нь маш ховор. Тиймээс үзэгчдэд нарийвчилсан мэдээлэл өгөхөөсөө өмнө үзэсгэлэнд ямар газар нутгийн тухай өгүүлэх ба үзмэрүүд өнгөрсөн үед хамаарах уу, өнөө үед хамаарах уу гэдгийг эхэлж тойм байдлаар таниулах нь зүйтэй тул дизайнер энгийн бичигдсэн танилцуулга тайлбарын зай төлөвлөхөө мартаж болохгүй. Тухайн сэдвийг мэддэг судлаачид танилцуулга тайлбарыг уншилгүй өнгөрөх хэдий ч жирийн үзэгчид талархан хүлээж авдаг.

Танхимын эхэнд голдуу уг овог аймаг, угсаатны газар зүйн байршлыг харуулсан хоёр газрын зураг байрлуулдаг. Нэг дэх нь тухайн тивийн газрын зураг дээр холбогдох газар нутгийг тодотгосон зураг байх ба хоёр дахь газрын зураг нь уг овог аймаг, угсаатны оршин суудаг газрыг хэсэгчлэн харуулсан байна.

Газар зүйн ийм мэдээлэл нь үзэсгэлэнгийн эхэнд барьж байгуулах бодит орчныг дууриалган хийсэн үзүүллэгийн салшгүй нэг хэсэг юм. Ийм дууриамал үзүүлэлэг нь газрын зургийг улам утга учиртай болгодог бөгөөд ийм орчныг нилээд

их тохиолдолд маш том хэмжээний гэрэл зураг, өнгө будаг ба уугуул нутгийн зарим нэг өвөрмөц эд зүйлээр бүрдүүлж өгдөг. Хэдий тийм боловч, дизайнер нь үзэгчийг тухайн газар нутгийн орчинд шууд оруулахаар зохиомжилж болно.

Үзэгчдэд илүү гүнзгий сэтгэгдэл төрүүлэхүйц болгохын тулд слайд, дүрс бичлэг болон кино өргөн ашигладаг бөгөөд тэдгээрийг үзэгчдэд тойм мэдээлэл өгөх багц арга болгон үзэсгэлэнгийн эхэнд оруулах нь олонтаа.

Үзүүлэлэг дэглэх стратеги

Үзэсгэлэнгийн эрдэм шинжилгээний ажилтан (куратор) ба дизайнер юуны өмнө үзмэрийг тайлбартайгаар хоргонд уламжлалт аргаар дэлгэн үзүүлэх нь тухайн үзмэрүүдийг толилуулах хамгийн сайн арга мөн эсэхийг шийдэх хэрэгтэй. Тэд үзмэрүүдээ илүү сэтгэгдэл төрүүлэхүйцээр зохион байгуулахыг хүсдэг. Үзмэрийн хадгалалт хамгаалалтын асуудал нь угсаатны бүлгийн амьдрах орчныг дууриалган нээлттэй, чөлөөтэй зохион байгуулах боломж бий эсэхийг шийднэ. Хэрэв зарим нэг үзмэр эмзэг, эсвэл өндөр үнэтэй бол үзэсгэлэнгийн зарим хэсгийг хоргонд байрлуулж, ил задгай үзүүлэлэгтэй хослуулах хэрэг гарна. Дизайнер хиймэл ой буюу урц сууцны дэргэд иж хоргуудыг ойрхон байрлуулж, бодит амьдралын орчин мэт сэтгэгдлийг үзэгчдэд бий болгох аргыг олох хэрэгтэй болно.

Ил задгай болон хоргонд тусгаарлагдсан үзмэрүүдийг зааглан байрлуулна. Зай талбай хангалттай тохиолдолд хооронд нь зай үлдээх буюу өнгийг нь аажмаар өөрчлөх замаар зааглаж өгч болно. Хэрэв танхим хангалттай өргөн бол хорготой үзмэрүүдийг байгууламжийн нэг талд зохион байгуулна.

Манекен ашиглах нь

Музейн куратор заримдаа бодит байдлыг дүрсэлсэн байгууламжид хэд хэдэн манекен байрлуулах хүсэлтэй байх нь бий. Манекен ахуй амьдралыг харуулахад төдийгүй уран дархчууд, тариаланчдын ажил хөдөлмөрийг дүрслэхэд хэрэгтэй байдаг. Гэхдээ дизайнер манекен ашиглахдаа хянамгай хандах шаардлагатай. Хувцасны үзүүлэлэгт хувцасны загвар хийц маягийг харуулж байгаа бол хиймэл хүмүүсийн толгойг зөвхөн загварчлан хийхэд л хангалттай. Харин тодорхой үйл хөдлөлийг орчинд нь хийж буй хүнийг дүрслэхэд илүү бодитой манекен хэрэгтэй болно. Ингэж нарийвчлахад хөрөнгө мөнгө их шаардагдаж төсвийн нилээд хэсгийг авч мэдэх юм. Нүүр царайны дүр төрхийг бодитой гаргахын тулд угсаатны онцлог ба сэтгэл зүйн зөв илэрхийллийг гаргах хэрэгтэй болно.

Муу хийгдсэн, үнэмшилгүй манекен юу юунаас ч илүү нийт үзэсгэлэнгийн уур амьсгалыг гутаадаг. Хэрэв дизайнер шаардлагатай ур хийц, чанар чансаатай манекен худалдаж авах хөрөнгө мөнгөний бололцоо муутай бол манекенийг

орчныг бүтээн харуулсан байгууламжаас хол байрлуулж, оронд нь тухайн ард түмний гэрэл зургийг бодит хэмжээтэй байрлуулна.

Дэглэлтийн арга хэрэгслүүд

Дуу чимээ

Бодит байдлыг дүрсэлсэн панорам - байгууламжийг байгуулахад хичнээн их хүч хөрөнгө зарцуулсан ч гэсэн дуу чимээгүй байвал үнэмшил багатай. Харин хээрийн шинжилгээний ангийн дуу бичлэг буюу тохирсон дуу чимээ тавьбал асар их үр нөлөө үзүүлнэ. Гэхдээ энэхүү дуу чимээ нь нарийн хяналтанд байж бусад үзүүллэгт бага зэрэг сонсогдох буюу бүр сонсогдохгүй, зөвхөн хамааралтай үзмэрийнхээ дэргэд л сонсогдож байх учиртай. Хэрэв үзэсгэлэнгийн өөр өөр хэсгүүдэд янз янзын дуу авианы бичлэгүүдийг явуулах шаардлагатай бол нэг цаг хугацаанд нэг л бичлэг явуулахаар цагийг зохицуулдаг.

Үзэгчид бүгдээрээ дуу чимээ сонсох сонирхолтой байдаггүй тул нэг газарт 10-20 минутын бичлэг байхад л хангалттай бөгөөд сонирхогч хүн илүү удаан сонсож болохоор хийнэ. Хэрэв үзэсгэлэн хэт их хүнтэй биш бол тухайн талбайд хүн орж ирмэгц бичлэг туяаны мэдрэмжтэй төхөөрөмжөөр юм уу эсвэл дардаг товчлуулаар ажиллаж эхлэнэ.

Үнэр

Ихэнх үзэсгэлэн аяндаа өөрийн гэсэн үнэртэй болсон байдаг. Хивсийг арласан нийлэг резин юм уу, будаг ба цавууны үнэр үзэсгэлэн нээснээс хойш ч байсаар байдаг. Ийм учраас хүнсний захын халуун ногоо, талхны газрын талх болон айл гэрийн үнэр оруулах нь тухайн уур амьсгалыг үзэгчдэд мэдрүүлэхээс гадна дизайн чимэглэлийн ажлын дараах үнэрийг дарахад тусалдаг. Дуу авианы нэгэн адилаар үнэрийг аль болох тухайн үзмэрийнх нь орчимд л байлгавал зохимжтой. Үзэсгэлэнгийн аль нэг хэсэгт өвс ургамлын үнэр оруулж өгч байгаа тохиолдолд тодорхой нэг хугацааны дараа түүнийг шинэчилж байх төсөв тусгах хэрэгтэй. Учир нь энэ арга бодит орчинд орсон мэт сэтгэгдэл төрүүлэх хямд төсөр арга юм. Хэрэв илүү их үнэр гаргах шаардлагатай бол сэнсээр түгээх үнэрийг дамжуулах хоолойг хэд хэдэн газар суурилуулдаг.

Засал чимэглэл

Бодит орчныг дууриалган хийсэн байгууламжийн дундуур үзэгчид чөлөөтэй явахаар, хашлагагүй байх нь тэдэнд хамгийн их таалагддаг. Дизайнер ингэж ил задгай үзүүллэг дэглэхээсээ өмнө үзмэрүүдийн хадгалалт хамгаалалт, аюулгүйн талын асуудлыг хангах ёстой. Хадгалалт хамгаалалтын асуудлыг үзүүллэгээ барьж байгуулах үедээ л нарийн тооцоолж шийдэхгүй бол засал чимэглэлийн ажилтай зөрчилдөж мэднэ.

Олон тохиолдолд өнгө будаг, засал чимэглэлийн ажилд илүү их цаг зарцуулж, нямбай хийснээр үзүүллэгийг чанартай хийх боломжтой болдог. Гэхдээ дизайнер зарим ашиглах боломжгүй аргаас татгалзах хэрэгтэй. Тухайлбал, цөлийг дүрслэхдээ жинхэнэ элс ашиглах бололцоогүй. Учир нь бужигнах тоос шороо тухайн танхимын үзмэр харагч нарт төвөг учруулахаас гадна музейд нийтэд нь асуудал үүсгэнэ.

Жинхэнэ бодит материалыг үзэсгэлэнгийн танхимд ашиглаж болохгүй нөхцөлд төстэй зүйлээр орлуулах буюу эх материалыг ямар нэг байдлаар аргалж ашиглах шаардлага гарна. Тухайлбал, ой модыг дүрсэлсэн хэсэгт тохирох өнгө бүхий зөөлөн хивсэнцэр дээгүүр үзэгч алхахад ойд яваа мэт сэтгэгдэл төрөх боловч танхимын хатуу шал нь ой биш гэдгийг мэдрүүлэх нь бий. Гэхдээ ихэнх үзэгчид дизайнер ба эрдэм шинжилгээний ажилтны нэгэн адил бодит дүрслэлд итгэхийг үнэн сэтгэлээсээ хүсч байдгийг дизайнер байнга санаж байх хэрэгтэй.

Хөдөлгөөний арга

Дизайнер салхинд намирах ханы бөс даавуу, нарны туяаг халхлах ногоон навчсын сэрчигнээн, эсвэл усны мандал дээр намуухан хөвөх завь гэх зэрэг хөдөлгөөн зэргийг ашиглан үзэсгэлэнгийн танхимд үнэхээр бодит мэт орчныг бий болгохыг чармайж байдаг. Хэрэв бодит байдлын дүрслэлд ямар нэг хөдөлгөөн оруулалгүй, том том лааны тосон баримал зэргийг үр нөлөөтэй хэмээн үзэж ашиглавал, үзэгчдэд төдий л үнэмшилтэй сэтгэгдэл төрүүлж чадахгүй, дэмий л нүсэр бүтээл болчихож болзошгүй. Дээр дурдсантай адил хөдөлгөөн оруулах нь үзэсгэлэнгийн төсөвт нэг их үнэтэй тусахгүй байх шаардлагатай бөгөөд энгийн тоног төхөөрөмжийн тусламжтайгаар зорилгодоо хүрэхийн тулд их бодох хэрэг гарна. Багахан сэнсээр үлээлгэн салхи гаргах, эсвэл бага оврын хөдөлгүүрээр дүрс баримлуудыг “амилуулах” хөдөлгөөнийг гэрэлтэй зөв хослуулах зэрэг энгийн аргыг хэрэглэж чадвал шилдэг кино студи-ын өмнө ч нүүр улайхааргүй үр дүнд хүрч чадна.

Гэрэлтүүлэг

Гэрэлтүүлгийг хийхдээ үзмэрийн хадгалалт хамгаалалтыг нэгдүгээрт тавина. Дизайнер хүн Африк тивийн хурц нарыг үзэсгэлэнд дүрслэх бодолтой байлаа гэж бодъё. Гэтэл харьцангуй бага хэсэгт тусгасан прожекторын хурц гэрэл болон цэгэн гэрэл нь үзмэрүүдийг бүрмөсөн сүйтгэчихгүй юмаа гэхэд гэмтээх түвшний гэрлийн ялгаралыг бий болгоно.

Сэргээн засварлагчид энэ асуудлыг шийдвэрлэх зорилт тулгарах бөгөөд түүнд дизайнер хоёр арга замаар тусалж чадна. Жинхэнэ эх үзмэрүүд ашигласан бодит орчны зохиомжийг хийхдээ үдшийн бүрэнхий болсон мэт шийдэж болно. Эсвэл зохиомжийн байгалийг дүрсэлсэн буюу арай хол орших гадна талыг хурц

гэрэлтүүлж, эмзэг жинхэнэ эх үзмэр бүхий дотор талыг бүдэг гэрэлтэй нь үлдээнэ.

Англи хэлнээс орчуулсан МҮМ-н **Д.Бумаа Ph.D**
МҮМ-н Музей судлалын мэргэжил арга зүйн төвийн дарга

Margaret Hall. On display. A design Grammar for Museum Exhibition. Humanities Pr;
1st edition. 1987. Маргарет Холл. Үзүүллэг. Музейн үзэсгэлэнгийн дизайны дүрэм.
1987.